

# Living the Lotus 3

*Buddhism in Everyday Life*

2024

VOL. 222



Rissho Kosei-kai of Kolkata,  
Gaya, and Patna in India

Living the Lotus  
Vol.222 (2024.03)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Б.Мөнхцэцэг, Т.Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Ш.Зоригмаа  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami  
-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@  
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг тууцгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*





## “Хянамгай байдал” нь “энэрэл нигүүлсэл”-ээс үүдэлтэй

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо

### “Өөртөө хянамгай байх” нь бусдыг бодох сэтгэлээс үүсдэг

“Гэрийн бутанд нуугдах аалзны торыг авах гэснээ болив”. Зэн урсгалын Рёокан (1758–1831он) багштаны нигүүсэл дүүрэн, сэтгэл дулаацуулсан ийм шүлэг байдаг. Анзаарч харсан аалзны торыг цэвэрлэх гэснээ больж, амьдрах гэж хичээж байгаа жижигхэн амь насыг олж хараад, өөрийн эрхгүй гараа татаж авсан Рёокан багштаны инээмсэглэл нүдэнд харагдана.

Санаандгүй гаргаж байгаа жижигхэн үйлдлээс хүний биеэ барих чадварыг болон аливаа зүйлд хандах нигүүслийг мэдэрч болно.

Хянамгай байх талаар, Шагжамүни бурхан “бие, хэлээ тэвч”, “бие, хэл, сэтгэлдээ хянамгай байх нь сайн үйл” гэх зэргээр өнгөрсөн сарын дугаарт “ичиж зовох” гэдгийн тухай тайлбарласан шиг олонтаа дурдсан байдаг. Бид энэ үгийг ёс суртахууны хувьд байх л зүйл гэж хүлээж авах гээд байдаг боловч Рёокан багштаны шүлэгт илэрхийлсэн шиг хянамгай байх нь энэрэл нигүүлсэлтэй ижил зүйл юм болов уу гэж би бодож байна. Буддизм судлаач, мөн Соотоошүү урсгалын лам Нара Ясүаки (1929–2017он)-ийн хэлснээр, Шагжамүнигийн сургаал нь “бүгд [нигүүлсэнгүй сэтгэл]-ээс улбаатай айлдагдсан байдаг” гэгддэг.

Тэгвэл бид ч гэсэн Рёокан багшантай ижил зүйлийг хийж чадах болов уу гэж бодох үед, дутуу дулимаг өөрийгөө чадахгүй байх даа... гэсэн сул дорой мэдрэмж төрнө. Тэглээ ч гэсэн түүнийгээ анзаарч байвал өөртөө хянамгай, бусдыг бодох сэтгэлээр үг үйлдэл хийхийг хичээх хэрэгтэй.

Яагаад гэвэл Нара багштаны үгнээс харахад “нигүүлсэнгүй сэтгэл нь нигүүлсэнгүй байхыг хичээх, хэрэгжүүлэх гэсэн зүтгэлийн үр дүнд хөгжиж, цэцэглэдэг” учраас юм. Гэгээрсэн хүнээс л нинжин сэтгэл төрж, хянамгай үйлдэл гарна гэсэн үг биш юм. Бусдыг бодсон үг, үйлдлээс “бүгд холбоотой нэг бүхэл амь нас” гэдгийг анзаарах нь чухал бөгөөд энд л гэгээрэл байдаг юм.



### Жижиг хэрэгжүүлэлтээс дэлхийн асуудал хүртэл

Одоогоос 60 жилийн өмнөх 3-р сарын 4нд РКК байгууллагын гол дуган болох Их ариун ордныг барьсан жил, үүсгэн байгуулагч: “шашны байгууллага том сүм дуган барихад даалгавар биелэгдлээ гээд санаа амардаг” хэмээн айлдсан байдаг. Барилга байшин нь том байхаар л мундаг байгууллага болчихдог юм биш, мөн сүм дугантай болчихоор л зорилго биелсэн гэсэн үг биш, тэр барилга байшинд цуглах ижил сүсэг бишрэлтэй анд нөхөд бурханы сургаалаас суралцаж, үргэлж эрч хүч дүүрэн төлөв даруу, хянамгай үйлээ хийх бололцоог бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл бүс нутаг, нийгмийг, хүний сэтгэлийг дулаацуулах, эрч хүч нэмэх - тийм л байгууллага байсаар байх нь чухал гэдгийг үүсгэн байгуулагч дээрх үгээр дамжуулан хэлэхийг хүссэн болов уу.

Энэ утгаараа РКК байгууллагын “Нэг удаагийн хоолоо хандивля хөдөлгөөн”-ийг аль болох удаан хэрэгжүүлэх нь маш чухал. Энэ хөдөлгөөнийг Шинто урсгалын Шоорокү Яматояма байгууллагын гишүүд анх хэрэгжүүлж байсан юм. Сард хэд хэдэн удаа хоолоо хасаж, тэрхүү хассан хоолноосоо хэмнэсэн мөнгөө бусдын сайн сайхны төлөө хандивлах гэсэн нигүүлсэнгүй сэтгэлийн хэрэгжүүлэлт нь нийгэмд хувь нэмрээ оруулах үйлстэй ч холбогдсон түүхтэй. Иймэрхүү жижигхэн хэрэгжүүлэлтийг цаашдаа ч ач холбогдол өгч, үргэлжлүүлэхийг хүсэж байна.

Түүнчлэн дэлхийн шашинтнуудын энхийн чуулган гэх зэрэг, шашны урсгалын хүрээг давж найз нөхөд, дэлхий дахинд тулгамдаад байгаа асуудлуудыг шийдэхийн төлөө харилцан яриаг тогтмол хийх явдал нь чухал юм. Үүний төлөө оролцогч талууд даруу төлөв байж, нийтийн төлөө гэсэн сэтгэлээр өөрийгөө дөвийлгөх сэтгэлээ дарж, тэвчээртэйгээр оролцох хэрэгтэй. Үүсгэн байгуулагч энэхүү суурийг бүтээсэн нь бидний нэг бахархал бөгөөд иймэрхүү үйл ажиллагааг хэлбэр төдий болохоос сэргийлж, бид бүхэн үргэлж хянамгай байж, нигүүлсэнгүй гэсэн Шагжамүни бурхан багшийн сургаалыг үндэс дээр зогсон аливаа зүйлийг бодож тунгаан, үйлдэл хийх нь чухал гэж бодож байна.

Шагжамүни бурхан “алив зүйлд хянамгай тэвчээртэй ханддаг хүн, ичиж зовдог хүн бол өөрийгөө хамгаалж буй хэрэг юм” хэмээн хэлсэн байдаг. Энд дурдагдаж буй “өөрийгөө” гэдгийг “сансар огторгуйтай нэгэн цул болсон би” гэсэн байр суурьнаас хүлээн авбал үг, үйлдлээ тэвчих гэдгийн утга бидэнд илүү ойр, дэлхийн хаана ч байсан хүн бүр үг, үйлдэлдээ хянамгай болох болох болов уу.

«Косей» 2024 оны 3-р сарын дугаараас





# Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

## Гишүүн болвол

### Сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэх нь

Лам болж хүний хөлөөс хол газарт очин даяан хийхээс илүүтэйгээр бусадтай адилхан амьдралаар амьдарч гэр орон, сургууль, ажлын байр, хамт олон дундаа бурхны сургаалыг хэрэгжүүлэн сайн хүн болохын төлөө тасралтгүй хичээсээр байгаа хүмүүсийн цуглааныг лам бус хүмүүсийн буддист байгууллага гэдэг. Рисшо Косей Кай бол тэрхүү

эгэл хүмүүсийн нэгдсэн шашны байгууллага юм.

Сургаалыг хэрэгжүүлсэн ч ганцаараа байвал бууж өгмөөр санагдах тохиолдол бий. Тиймээс үлгэр дууриалал болох ахмадууд болон найз нөхдөөсөө асууж лавлан, үргэлж зөв сургаалыг сонсож, бие биедээ урам өгөн урагшлах нь чухал билээ.



\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.


#### Чимх мэдлэг

Рисшо Косей Кайд “бусад найр тавих”-ыг чухалчилдаг. Хүн даруу төлөв байснаараа өөрийн дотор орших бурхны сэтгэлийг ил гаргаж чаддаг. Энэ нь сэтгэлээ сайжруулахад нэн чухал үйл билээ.





## Номын андуудынхаа хамтаар (Санга)



Бурхны сургаалыг амьдралдаа хэрэгжүүлж, бусдад таниулж байж л үнэ цэнэтэй болдог боловч ганцаараа хийвэл шантарч, хэрэгжүүлэхэд амаргүй. Тиймээс Бурхан багш сургаал номыг хамтдаа суралцдаг хүмүүсийн нэгдлийг “Мөргөлийн Гурван эрдэнэ”-ийн нэг болгон (хуудас 130) оруулсан байдаг. Үүнийг Санга буюу номын анд гэнэ.

Найз нөхөдтэйгөө хамт байхад залхуурлаас зайлсхийхээс гадна мэдэхгүй зүйл гарахад заалгуулж авах боломжтой болдог. Мөн бие биенээ хурцалж хамтдаа хөгжиж чаддаг. Тиймээс сайн найз, хамтрагчтай байх нь маш чухал юм.

### Чимх мэдлэг

“Санга” нь эртний энэтхэгийн “цуглаан, бүлэг” гэсэн утгатай үг бөгөөд Буддын шашинд “шашны зам мөр хөөгчдийн цуглаан”-ыг хэлдэг. Энэтхэгийн Буддизмд санга гэж зөвхөн лам нарыг заасан байдаг боловч өнөөгийн японы буддизмд лам бус энгийн хүмүүс ч багтдаг.



## Залбирлын бичиг дэх авралын эхлэл

Акагава Кэйичи

Сайн байцгаана уу, энэ сард ч бас хэлтсийн даргын буланг уншиж байгаад баярлалаа. 3-р сарын ерөнхийлөгчийн айлдвар “Өөртөө хянамгай байдал нь энэрэн нигүүлсэхүйн сэтгэлээс үүдэлтэй” гэсэн гарчигтай байв. Айлдварыг уншихад хамгийн түрүүнд “Бие хэл сэтгэлийн гурван үйл” гэсэн үг санаанд орж ирлээ.

Их Ариун Ордонд залсан Ялж төгс нөгчсөн Язгуурын бурхан Шагжамүнигийн их биед Үүсгэн байгуулагчийн хуулан бичсэн Лянхуан гурамсан судрын хамт түүний гол шүтээн бүтээх тухай шийдвэрийг илэрхийлсэн залбирлын бичиг хадгалагддаг билээ.

1960 оны 10 сард Цагаан лянхуа судрыг хуулбарлаж дуусах үед бичигдсэн энэхүү залбирлын бичигт доорх хэсэг бий. “Гурван хөлгөний дагуу гурван үйлийг хичээн замнах нь нирваанд хөтлөх агуу зам юм”. Энэ нь төгс гэгээрэлд хүргэх гурван зам мөр болох “Хутагтын дөрвөн үнэний сургаал”, “Арван хоёр шүтэн барилдлага”, “Зургаан барамид”-ын сахилга батыг баримтлан, бие хэл сэтгэлийн гурван үйлийг хянаж, учирсан учрал бүрийг баяр баясгалан, хүсэл эрмэлзлээр дүүрэн болгохын чухлыг зааж буй сургаал болно.

Манай байгууллагын гишүүдийн зорьж буй “Сэтгэлээ сайжруулах үйл” бол өдөр тутам эргэн тойрныхондоо анхаарал халамжтай, өөрийн үг үйлэндээ хянамгай амьдрахаас эхэлдэг. Энэ жил Ариун ордныг байгуулсаны 60 жилийн ой тохиож байна. Яг одооноос энэрэн нигүүлсэхүйн үйлийг хэрэгжүүлж, Үүсгэн байгуулагчийн хүслийг шингээсэн залбирлыг үгсийг даган баясах цаг биш гэж үү?



2023 оны 10 сарын 29-ний өдөр Номын багшийн цол гардуулах ёслолд оролцсон гадаад дахь салбарын гишүүдийн хамт Их Ариун ордны гол хаалганы өмнө (Урд эгнээний зүүн гар талаас 2 дахид Акагава хэлтсийн дарга)




# Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



## 🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



twitter



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)